



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 05 сарын 15 өдөр

Дугаар 218

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Сангийн яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 13,145,000.00 (арван гурван сая нэг зуун дөчин таван мянган) төгрөгийн балансын үнэ, 11,354,820.44 (арван нэгэн сая гурван зуун тавин дөрвөн мянга найман зуун хорин төгрөг дөчин дөрвөн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг Шинжлэх ухааны академийн Физик, технологийн хүрээлэнд балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Наранцогт, Шинжлэх ухааны академийн Физик, технологийн хүрээлэнгийн захирал П.Алтанцог нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА


ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ц.НЯМ-ОСОР

Э.ЭРДЭНЭХИШИГ

0001709

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн
248 дугаар тогтоолын хавсралт



Сангийн яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй
балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Тоо, ширхэг	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Тогоо (1-р хоолны)	2012	1	2,871,000.00	2,871,000.00	
2	Пийшин 4 ширэмтэй	2012	1	2,310,000.00	2,310,000.00	
3	Хөргөгч 4 хаалгатай	2012	1	1,650,000.00	1,627,083.57	22,916.43
4	Хоол халуун байлгагч	2012	2	2,640,000.00	1,562,000.00	1,078,000.00
5	Ус буцалгагч 60 л	2012	1	286,000.00	286,000.00	
6	Шарах шүүгээ	2012	1	638,000.00	638,000.00	
7	Буузны жигнүүр	2012	1	638,000.00	638,000.00	
8	Будаа агшаагч	2012	1	286,000.00	286,000.00	
9	Мах шарагч	2012	1	330,000.00	330,000.00	
10	Хуушуурын тогоо	2012	1	231,000.00	231,000.00	
11	Хөргөх лангуу	2012	1	1,265,000.00	575,736.87	689,263.13
	Дүн			13,145,000.00 (арван гурван сая нэг зуун дөчин таван мянган)	11,354,820.44 (арван нэгэн сая гурван зуун тавин дөрвөн мянга найман зуун хорин төгрөг дөчин дөрвөн мөнгө)	1,790,179.56 (нэг сая долоон зуун ерэн мянга нэг зуун далан есөн төгрөг тавин зургаан мөнгө)